


СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

БАТЛАВ:
ДАРГА: Н.ӨНХБОЛД
Огноо. 2020 оны 04 дугаар сарын 28-ны өдөр



“5 ДУГААР ХОРОО, 59 ДҮГЭЭР БАЙРНЫ ДЭЭВЭР ЗАСВАР ХИЙХ”
АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: “5 дугаар хороо, 59 дүгээр байрны дээвэр засвар хийх”

Төслийн дугаар: СБД-ХААА/ОНХС20-004

Санхүүжүүлэх эх үүсвэр: Дүүргийн ОНХС-ийн хөрөнгө оруулалт

2020 он

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Үнийн санал авах урилга хүргэх тухай

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос СБД-ХААА/ОНХС20-004 дугаартай “5 дугаар хороо, 59 дүгээр байрны дээвэр засвар хийх” – ын ажлын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж баримт бичгийг татаж авна уу.

Тендерт оролцогч нь холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, эрх бүхий хуулийн этгээд байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерт оролцох хураамж болох 50000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг 2020 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн 11 цаг 20 минутаас өмнө системд ирүүлэх ба үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн 11 цаг 50 минутанд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны 205 тоот өрөөнд нээнэ.

Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг 7 дугаар хороо, Денверийн гудамж, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны 2 дугаар давхар 205 тоот өрөө, Худалдан авах ажиллагааны алба, утас 70107632.

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт 2. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ зөрчсөн эсэх талаарх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт, шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлэх 3. Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээлийн болон зээлийн хүүгийн өр төлбөргүй тухай тодорхойлолт 4. ЭМНД-ийн хэлтсийн өргүй тухай тодорхойлолт <p><i>/ Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсанаас хойших хугацаанд бүрдүүлэн ирүүлэх ба тус цаг хугацаанд хамаарахгүй тодорхойлолт ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болно. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ./</i></p> <ol style="list-style-type: none"> 5. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Захиалагч цахим системээр дамжуулан тендер оролцогчдын татвар төлөлтийн мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байхаар тооцож шалгана.
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендер оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 06-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 20 минут</p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг 7 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Денверийн гудамж, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны 2 давхар 205 тоот өрөөнд</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 06-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 50 минут</p>
<p>ТӨӨЗ 3.1</p>	<ul style="list-style-type: none"> - Үнийн санал /маягтын дагуу/ ирүүлэх - Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг ирүүлэх
	<p>Борлуулалтын орлого : [Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он]</p>

<p>ТӨӨЗ 3.1 /в/</p>	<p>Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жил тус бүрт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх.</i></p> <p>Санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй бөгөөд Захиалагч цахим системээр дамжуулан тендерт оролцогчдын санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байхаар тооцож шалгана.</p> <hr/> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Сүүлийн 2 жил [2018, 2019 он]</p> <p><i>Сүүлийн 2 жил тус бүрт санал болгож байгаа үнийн дүнгийн 50 хувиас багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх. /Энэ нь баримт бичигт шаардсан тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдсэн ажил байх/</i></p> <p>Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, улсын комисс хүлээж авсан актын хуулбар, фото зураг, тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ 3.1 /г/</p>	<p>Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: [тийм]. Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрх бүхий хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, түүний заалт. Үүнд:</p> <p>БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил /Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 02 сарын 23-ны өдрийн 33 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дүйцүүлж болно/ Мөн барилга байгууламжийн угсралт, өргөтгөл шинэчлэлийн ажлын холбогдох зөвшөөрөлтэй байж болно.</p> <p><i>Тусгай зөвшөөрлийн хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд болон ажил гүйцэтгэж дуусах хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлнэ. Тусгай зөвшөөрөл нь гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй байна.</i></p>
<p>ТӨӨЗ 3.1 /д/</p>	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар хувь; 2. Тусгай зөвшөөрлийн хуулбар хувь 3. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлэх./маягтаар/ 4. Харилцагч банк, шүүх, ШШГЕГ, татвар, ЭМНД-ийн хэлтсээс тодруулга авахад татгалзах зүйл үгүй гэсэн албан тоотыг тендерийн материалд ирүүлэх 5. Төсвийг зураг, ажлын тоо хэмжээний дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ. <ul style="list-style-type: none"> - ЗТБХБ-ын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 18 тоот, 2012 оны 181 дүгээр тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу тооцно. - БХБСайдын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тушаалын дагуу зохиогчийн хяналтын зардлыг тооцож ирүүлнэ. - Магадлашгүй ажлын зардал, норм нормативийн сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуульд нийцүүлэн тус тус тооцож ирүүлнэ. - Захиалагч байгууллагаас зураг төсвийн үнийг тендерийн үнийн саналд тусгуулахаар заасан тохиолдолд төсөвт тооцож ирүүлнэ. - Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ. - Үнийн хөнгөлөлт тооцсон тохиолдолд задаргаа болон үндэслэлийн хамт ирүүлнэ.

- Төсөвт арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, давуу эрх эдлэх этгээдийн хувь хэмжээг тооцож, үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Их хэмжээний зөрүүтэй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.

6. Тендерт оролцогчийн туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн **10** хүртэл хувь байна. Туслан гүйцэтгэгчээр ажил гүйцэтгүүлэх бол гэрээ байгуулж, тендерт хавсарган ирүүлнэ. Түүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба ТӨӨЗ-д дурдсан бусад шалгуурыг хангасан байх шаардлагатай.

7. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтыг доорх маягтаар ирүүлнэ.

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Тодорхойлолт, хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа (жилээр)	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), ба тоо ширхэг	Өөрийн, түрээслэх, эсхүл худалдаж авах (хаанаас?)

Машин механизм нь тухайн байгууллагын эзэмшилд байгаа тохиолдолд болон түрээсээр ашиглах техник, тоног төхөөрөмжийн хувьд тоног төхөөрөмжийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулан түрээсийн гэрээг хавсаргана. Үүнд:

Тээврийн хэрэгслийн гэрчилгээ

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөгчийн гэрчилгээ

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тайлан-НТТҮО-04 /байгууллагын нэр дээр байгаа тохиолдолд/

Фото зураг /машины дугаар тодорхой харагдаж байх/

Машин механизм, тоног төхөөрөмжийн хуваарилалт

Тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагааг хувь хүний нэр дээр байгаа тохиолдолд ТҮЦ машинаас ирүүлэх. Байгууллагын нэр дээр бол Авто тээврийн үндэсний төвийн тодорхойлолтоор нотолно Гэрчилгээнүүдийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай.

Ачааны автомашин – 5 хүртэл тн -1 ш, Авто кран 5 тн -1 ширхэг

Түрээсээр ашиглах машин механизмын хувьд гэрээнд тухайн ажлын нэр, ажлын дугаарыг тусгасан байх шаардлагатай.

8. Боловсон хүчний талаарх мэдээлэл: Инженер болон удирдах албан тушаалтны дадлага туршлагатайг нотлох баримт ирүүлэх:

Гэрээг хариуцан ажиллах Инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан тендерт оролцогч байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай ба сүүлийн 6 сараас багагүй хугацаанд тухайн байгууллагад НДШ төлсөн байх. үүнийг НД-7, НД-8 дугаар маягтын сүүлийн 6 сарын баталгаажуулсан тайлан, ТҮЦ машины лавлагаагаар нотолно. Үндсэн ажилтны сургууль төгссөн диплом, нийгмийн даатгалын дэвтэр /ажилд орсон тушаал, шимтгэл төлсөн нүүрүүдийг тус тус хуулбарлах/, иргэний үнэмлэх, мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. Туршлагын мэдээллийг жагсаалтаар ирүүлнэ.

Бусад мэргэжлийн ажилтны мэдээллийн жагсаалтыг мэргэжлийн үнэмлэхний хуулбар болон иргэний үнэмлэхний хуулбарын хамт ирүүлнэ. Тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд хамгийн багадаа 4 мэргэжилтэй ажилтныг санал болгох ба тухайн ажилтнууд нь хамгийн багадаа мэргэжлээрээ 1 жилээс багагүй хугацаанд ажилласан туршлагатай байх, үүнийг түц машины лавлагаагаар нотолно.

9. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.

10. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт. Үүнд судлагдсан зээлийн тодорхойлолт хамаарагдах төсөл арга хэмжээний нэр болон дугаарыг тодорхой заасан байна. Судлагдаагүй зээлийн тодорхойлолт ирүүлэх, төсөл арга хэмжээний нэр болон дугаар дурьдагдаагүй тодорхойлолтыг шаардлага хангаагүйд тооцно.

Байгууллагын дансны үлдэгдэл /2020 оны 04 дүгээр 23-ний өдрөөр тасалбар болгосон хуулга/

2019 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлангаарх түргэн хөрвөх яадвартай хөрөнгө /ТХЧД болон авах боломжтой зээлийн дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /e/-д заасны дагуу тодорхойлно/.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн чадварыг зөвхөн дээр дурьдсан 3 баримтаар нотлох бөгөөд бусад төрлийн нотолгоог үнэлгээнд хүлээн зөвшөөрөхгүй буюу шаардлага хангаагүй гэж үзнэ.

11. Тендерийн баримт бичгийн 8, 9 дүгээр бүлэгт заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа эсэх талаар мэдэгдэл ирүүлнэ.

12. Ажлын талбайтай танилцсан тэмдэглэл ирүүлнэ.

13. Тендерт оролцогч нь хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаархи мэдээллийг бичгээр ирүүлнэ. Дээрх мэдээллээр тендерт оролцогчийн тухайн гэрээг гүйцэтгэх санхүүгийн болон техникийн чадавхийг үнэлэхэд харгалзан үзнэ. Тус мэдээллийг ирүүлээгүй буюу захиалагчийн зүгээс авсан лавлагаатай зөрүүтэй мэдээлэл ирүүлсэн тендерт оролцогчийн ерөнхий нөхцлийг магадлах шалгуурыг хангаагүй гэж үзэн захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.

14. Тендерт оролцогч нь захиалагчаас тухайн өдөр зарласан ижил төрлийн 2 болон түүнээс дээш тооны ажил гүйцэтгэх тендерт санал ирүүлж буй тохиолдолд зөвхөн тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулах машин механизм болон мэргэжлийн ажилтнуудыг танилцуулах бөгөөд давхацсан, ажиллах хүчний болон тоног төхөөрөмжийн хуваарилалт ирүүлээгүй тохиолдолд энэ нь тендерээс татгалзах үндэслэл болно.

15. Уг ажлыг гүйцэтгэхэд ашиглагдаж буй материал түүхий эд болон тухайн ажлыг гүйцэтгэх менежмент нь Байгаль орчинд ээлтэй технологиор гүйцэтгэсэн бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.

16. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, ажил гүйцэтгэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ.

17. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.

18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан тендерт оролцогч этгээдэд давуу эрх олгоно. Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол нотлох баримт ирүүлэх :

а/ Тус ажлын саналд монгол улсын гарал үүсэлтэй бараа ашиглах бол - албан хүсэлт

	<p>-барааны нэгж үнэ нийт үнийн тооцоолол, -барааны тохирлын гэрчилгээ, Монгол улсын үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ /гэрээ нь тухайн ажил болон цаг үед хамаарах/ б/ Орон нутгаас хамгийн их ажиллах хүч авахаар санал болгосон бол мөн нотлох баримт үүнд: албан хүсэлт ажиллах хүчний гэрээ /Тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагатай хийсэн/ Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалаар батлагдсан Давуу эрх тооцох аргачлалыг тус тус баримтлана.Тендерт оролцогч албан хүсэлт болон хуулийн 10 дугаар зүйлд заасан нотлох баримтыг ирүүлээгүй бол давуу эрхийг тооцохгүй. Захиалагч дараах тохиолдолд тендерт оролцогчийн тендерээс татгалзана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Захиалагчаас тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон буюу гэрээ байгуулахаар хүлээгдэж байгаа бол, - Захиалагчтай байгуулсан гэрээгээр ижил төстэй ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байгаа тохиолдолд түүний гүйцэтгэл бүрэн дүгнэгдээгүй бол тус тус татгалзана. <p>ТШӨХ-д заасан аль нэг баримт бичгийг дутуу ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 6.1	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: /"5 дугаар хороо, 59 дүгээр байрны дээвэр засвар хийх", СБД-ХААА/ОНХС20-004/
ТӨӨЗ 22.1	Тендерийн ЭХ ХУВЬ -иас гадна ХУУЛБАР ХУВЬ : ирүүлэхгүй
	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Дүүргийн ОНХС-ийн хөрөнгө оруулалт Батлагдсан төсөвт өртөг: 19,892.2 сая төгрөг

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn - д өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний 02-07-383/448 дугаар дүгнэлт: Шалгалтаар орон сууцны барилгын дээврийн хар цаасан хучлагын ам даруулж наасан наалт, залгаас ховхорч, хагарч гэмтсэн, ус гүйж хавагнаж тогтсон, дээвэр дээр байрлах хийцүүдэд наагдсан хучлага ховхорч зай, завсар үүссэн, урагдаж, цоорсон, дээд давхруудад байрлах сууцнуудын таазнаас ус нэвчиж замаск, эмульс ховхорч унасан, ашиглалтын явцад дээврийн хар цаасан хучлагыг хэсэгчлэн нөхөж засварлах ажил хийгдэж байсан ч дээврээс ус нэвчих байдал зогсоогүй, их засварын ажил хийгдэж байгаагүй ба үүссэн нөхцөл байдал нь ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж байна.

Дээрх байдлыг үндэслэн ДҮГНЭХ нь:

Орон сууцны 59 дүгээр байрны дээвэр нь Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-04-03 дүрмийн 2.5 заалт /барилга байгууламжийн бүрдэл хэсгийн үр ашигтай ашиглалтын хугацааны хамгийн бага үргэлжлэх хугацааг дээврийн хучлага хуйлмал материалан 3-4 үетэй дээвэрт 10 жил/-гэсэн шаардлагыг хангахгүй байна.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь /Орон сууцны байшингийн ашиглалтын хугацаанд дундын өмчлөлийн эд хөрөнгөд хамаарах дээвэр, ... зэрэгт их засвар хийх үед их хэмжээний хөрөнгө шаардагдах бол барилгын хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс нэг удаа санхүүжүүлж болно./ заалтын дагуу шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Ажлын тоо хэмжээ

№	Гүйцэтгэх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Хуйлмал материалан дээвэр буулгах	м2	544
2	Цементэн тэгшилгээ буулгах /30 хувийг/	м2	136
3	Дээврийн 15мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	136
4	Дараагийн 1мм тутамд үнэлгээ 30-д нэмэх	м2	816
5	Агааржуулалтын тоосгон хана өрөх	м3	0.4
6	Агааржуулалтын хана цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	2.4
7	Агааржуулалтын хана эмульсэн будгаар будах	м2	2.4
8	Дээврийн ус тусгаарлах үеийн хөрсжүүлэлт хийх	м2	544
9	Линокром чулуугүй хар цаас 2 үе наах	м2	1088
10	Линокром чулуутай хар цаас 1 үе наах	м2	544
11	Дээврийн ирмэгээр хар цаасны доор хаялга хийх	м2	23.8
12	Барилгын хог ачих	м3	9.25

Тав. ЗУРАГ

Ажлын зургийг www.tender.gov.mn сайтад /ТЭЗҮ хэсэгт/байршуулав.

Ажлыг гүйцэтгэх технологийн аргачлал, календарчилсан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь чанарын гологдолгүй ажиллахад анхаарах хэрэгтэй. / Зургийг хавсаргав/

ҮНЭЛЭГДСЭН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

	Ажилбар	Гэрээт хугацаа				НИЙТ
		... хоног	... хоног	... хоног	... хоног	
1						

2						
3						
4						
5						
6						
7						
8						
	БҮГД					

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]**-ыг **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч _____ Компанийн _____ ажилтай _____ овогтой _____ нь _____ компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул _____ ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

_____ нь _____ компанийг төлөөлж _____ компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах, гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 2020 оны _____ дугаар сарын _____ ны өдөр гарын үсэг зурав.

Тэмдэг Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____
Албан тушаал _____

Баталгаажуулагчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____
Албан тушаал _____

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|-------------------------------|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан |

өдөр ажил дууссан байх	тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. Аюулгүй байдал	<p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p>
5. Зааварчилгаа	5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. Маргааныг шийдвэрлэх	6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. Ажлын хөтөлбөр	<p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p>
8. Зөрчил, гологдол илрүүлэх	8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. Зөрчил, гологдол арилгах	<p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p>
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “5 дугаар хороо, 59 дүгээр байрны дээвэр засвар хийх”, СБД-ХААА/ОНХС20-004
- 1.2 Ажил нь:
“5 дугаар хороо, 59 дүгээр байрны дээвэр засвар хийх”
- 1.3 Төслийн менежер: Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, мэргэжилтэн Ц.Бэлгүдэй
- 1.4 Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс
Ажил эхлэх өдөр: Тендерийн зөвлөмж гарч гэрээ байгуулагдсан өдрөөс
- 1.5 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Тендерийн зөвлөмж гарч гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн **хуанлийн 30 хоногт** ажлыг дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх.
- 1.6 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш **[5]** хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 1.7 Чанарын баталгаат хугацааны шаардлага **[48] сар** байна.
- 1.8 - Урьдчилгаа төлбөр олгож болно. Баталгаа нь гэрээний хугацаа дуусах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.
Гэрээгээр хүлээсэн хугацааг хоцроосны алданги ногдуулах хувь, хэмжээ /хоног тутамд/: Гэрээний үнийн дүнгийн 0,1%. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 5%-с хэтрэхгүй байна.
- 1.9 Ажлын гүйцэтгэлийн явцад мэдээллийн самбар байршуулна.
Барьцаа хөрөнгийн хэмжээ /хувиар/, байрших хөрөнгийн хугацаа /сараар/: 5%, 12 сар.
- 1.10 Ажлын гүйцэтгэлийг хүлээн авах эцсийн хугацаа /төслийн менежерээс мэдэгдэл гарснаас хойш **ажлын 7 хоног**/
- 1.11
1. “Барилга захиалагчийн дүрэм”, “Дүүргийн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах, хяналт тавих журам”-н дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлнэ.
 2. Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм батлах тухай 178 дугаар тушаалын дагуу зохиогчийн хяналтыг хэрэгжүүлнэ. Зохиогчийн хяналтын дүн захиалагчийн хяналтын 50 хувь байна.
 3. Магадлашгүй ажлыг хэрэгжүүлэх тохиолдолд тухай бүрт төслийн менежерт танилцуулж, захиалагчтай харилцан зөвшилцсөний дагуу гүйцэтгэнэ.
 4. Нэмэгдэл зардал 61 хувиар тус тус тооцно.

5. Ажлын гүйцэтгэлд Монгол улсын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Жагсаалт батлах тухай 336 дугаар тогтоолыг баримтална.
6. Ажлын гүйцэтгэлийн явцад мэдээллийн самбар байршуулна.
7. Ажлын гүйцэтгэлд тохижилтын ажил бүрийн өртгийн жагсаалтыг хамт хүргүүлсэн байна.
8. Гэрээ, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөрчсөн тохиолдолд захиалагч дангаараа гэрээг цуцалж болно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр,

бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт ____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]